



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**11**  
АНГИ

# НИЙГЭМ СУДЛАЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоог дараах ойлголтуудаас алийг нь илэрхийлж байна вэ?  
A. нийгмийн ялгарал  
B. нийгмийн тэгш бус байдал  
C. нийгмийн давхраа  
D. нийгмийн давхраажилт
2. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурийг харьцуулахад өөрчлөлт гарсан бол аль шилжих хөдөлгөөнд харьяалагдах вэ?  
A. босоо шилжих хөдөлгөөн  
B. хувийн шилжих хөдөлгөөн  
C. үе хоорондын шилжих хөдөлгөөн  
D. үе дотоодын шилжих хөдөлгөөн
3. “Анги бол үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа, түүнээс хамааруулан амьдрах нөхцөлөө бүрдүүлэх аргаараа ялгаатай нийгмийн томоохон бүлэг” гэж дараах эрдэмтдийн аль нь үзсэн бэ?  
A. К. Маркс  
B. Г. Спенсер  
C. М. Вебер  
D. Т. Парсонс
4. Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд илүү өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг гэж дараах эрдэмтдийн хэн нь үзсэн бэ?  
A. К. Маркс  
B. Э. Дюркгейм  
C. Дэвис, Мур  
D. Л. Уорнер
5. Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг юу гэж нэрлэдэг вэ?  
A. соёлын даяаршил  
B. соёлын аялал жуулчлал  
C. соёлын адилсал  
D. соёлын үйлдвэрлэл
6. Соёлын аялал жуулчлалын төрөл аль нь вэ?  
A. дотоодын аялал жуулчлал, гадаадын аялал жуулчлал  
B. дотоодын аялал жуулчлал, олон улсын аялал жуулчлал  
C. үндэсний аялал жуулчлал, олон улсын аялал жуулчлал  
D. гадаад аялал жуулчлал, үндэсний аялал жуулчлал
7. Соёлын аялал жуулчлал гэсэн ойлголтыг хэдэн оноос эхлэн хэрэглэсэн бэ?  
A. 1970 он  
B. 1980 он  
C. 1990 он  
D. 2000 он

8. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлүүдийг зөв байршуулна уу.

Өгөгдлүүд: /1-Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгох; 2-Түүх, соёлын үнэт зүйлийг нийтийн хүртээл болгох; 3-Соёлын аялал жуулчлалын ач холбогдол/

Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдол	<b>a</b> .....
<b>b</b> .....	Бусдын соёлд хүндэтгэлтэй хандах
Ажлын байр нэмэгдэх	<b>c</b> .....

A. a3,b1,c2                      B. a3,b2,c1                      C. a2,b3,c1                      D. a2,b1,c3

9. Хуулийн дагуу, тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамжийг юу гэж нэрлэдэг вэ?

A. хураамж                      B. татвар                      C. бонд                      D. татаас

10. Мөнгөний тэлэх бодлого аль нь вэ?

- A. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлого
- B. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
- C. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого
- D. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого

11. Дараах эрдэмтдийн алиных нь онол макро эдийн засгийн онолын цаашдын хөгжил болон барууны орнуудын төрийн эдийн засгийн бодлогод чухал нөлөө үзүүлсэн бэ?

A. А. Смит                      B. Ф. Хайек                      C. М. Кейнс                      D. Д. Рикорда

12. Эдийн засгийн амьдрал, логик, ёс зүй болон социализмын шинжлэх ухааны үндэслэлийг бүх талаас нь авч үзсэн ч маш алдаатай байсан гэдгийг хэн нотолсон бэ?

A. Смит                      B. Ф. Хайек                      C. М. Кейнс                      D. Д. Рикорда

13. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.

1992 онд Бразилын Рио де Жанейро хотод НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн дээд хэмжээний бага хурал болсноос хойш ..... гэдэг ойлголт дэлхийд өргөн дэлгэрсэн.

- A. хөгжлийн эдийн засаг                      C. тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
- B. эдийн засаг-хөгжил                      D. тогтвортой хөгжил

14. Эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг юу гэж нэрлэдэг вэ?

- A. эрх зүй                      C. эрх зүйн зөрчил
- B. гэмт хэргийн зөрчил                      D. гэмт хэргийн бус зөрчил


15. Тодорхойлолтуудаас аль нь хүндэтгэх үүрэг вэ?

- A. Тухайн эрхийг эдлэхэд ямар нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх үүрэг хүлээдэг
- B. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нь сэргээх үүрэг хүлээдэг
- C. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох арга замыг авах үүрэг хүлээдэг
- D. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлах үүрэг хүлээдэг

16. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг хэдэн онд баталсан бэ?  
 А. 1948 он                      В. 1966 он                      С. 1996 он                      Д. 2000 он
17. Хэрэг үүсгэх өдрөөс хойш нийслэлд хэд хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах вэ?  
 А. 7 хоног                      В. 14 хоног                      С. 21 хоног                      Д. 30 хоног
18. Дараах бүдүүвчид өгсөн өгөгдлүүдийг зөв дараалалд оруулна уу.  
 Өгөгдлүүд: /1-Гомдол хүлээн авах бүртгэх, 2-Гомдлын мөрөөр шалгалт хийх, 3-Гомдлыг шийдвэрлэх, 4- Гомдлыг шийдвэрлэх үйл явц/



- А. a4,b1,c3,d2                      В. a4,b1,c2,d3                      С. a1,b2,c3,d4                      Д. a1,b2,c4,d3
19. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.  
 XVIII зууны сүүл, XX зууны эхэн үед ..... гэдэг ойлголт нь улс төрийн шинжлэх ухаанд тусгай бие даасан ойлголт болсон. Энэхүү ойлголт нь “civilis” буюу соёлтой гэсэн үгнээс гаралтай.  
 А. төр                      В. нам                      С. иргэний нийгэм                      Д. лоббизм
20. “Аливаа зүйлийг хийж бүтээнэ гэдэг нь өчүүхэн ч атугай бусадтай чөлөөтэй хамтран ажиллана гэсэн үг. Энэ нь чөлөөт эсвэл холбоо болон байгууллагуудын сүлжилдсэн ертөнц болж дараа нь бие даасан институтууд бий болгоход хүргэдэг” гэж хэн хэлсэн бэ?  
 А. Р. Дарендорьф                      В. Г. Гегель                      С. Р. Путнам                      Д. Д. Истон
21. Төр хэний эрх ашгийг хамгаалдаг вэ?  
 А. ард иргэдийн                      В. бүлэг, байгууллагын                      С. нийтийн                      Д. хувь хүн
22. Д. Истоны улс төрийн загварт тохирох өгөгдлийг зөв байршуулна уу.  
 Өгөгдлүүд: /1-дэмжлэг, 2-шийдвэр, 3-эргэх холбоо, 4-хувиргалт/



- А. a1,b3,c2,d4                      В. a1,b4,c2,d3                      С. a2,b4,c1,d3                      Д. a1,b2,c3,d4
23. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ?  
 А. олон улсын харилцаа                      С. олон улсын эрх зүй  
 В. улс бус оролцогч                      Д. гуравдагч хөршийн бодлого

24. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны глобал түвшинд аль нь хамаарах вэ?

- A. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
- B. Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
- C. Аль Кайда бүлэглэл
- D. Евразийн эдийн засгийн холбоо

25. Зөв харгалзуулна уу.

a	Монгол улстай стратегийн түншлэл улс	1	ОХУ
b	Монгол улстай өргөн хүрээтэй түншлэл улс	2	БНСУ
c	Монгол улстай иж бүрэн түншлэл улс	3	Канад

A. a2,b1,c3

B. a1,b2,c3

C. a2,b3,c1

D. a1,b3,c2

### САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1; 2.2; 2.3) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу зөв хариултыг будаарай.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

#### 2.1 Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Гэм хор	1	Эрүүгийн хэрэгт заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл
b	Хохирол	2	Шууд бий болсон үр дагавар
c	Хор уршиг	3	Хохирлын улмаас бий болсон үр дагавар
d	Гэмт хэргийн зөрчил	4	Хохирол, хор уршгийг багтаасан ойлголт
e	Гэмт хэргийн бус зөрчил	5	Эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл

#### 2.2 Ардчилсан сонгуулийн зарчмуудыг зөв харгалзуулна уу.

a	Бүх нийтээр сонгох зарчим	1	Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр тооцдог байх
b	Сонгуульд тэгш оролцох зарчим	2	Сонгуульд оролцохдоо чөлөөтэй сонголтоо хийх, чөлөөтэй илэрхийлэх
c	Саналыг шууд өгөх зарчим	3	Сонгогч ямар нэг дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх
d	Чөлөөтэй сонгох зарчим	4	Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцдог байх
e	Саналаа нууцаар гаргах зарчим	5	Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй

#### 2.3 Олон улсын харилцааны онолыг үндсэн үзэл баримтлалтай нь зөв харгалзуулна уу.

a	Үндэстэн дамнасан корпорац	1	Үзэл сурталжсан хүчирхийлэлд үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, тэмцлийн хурц, сөрөг арга хэлбэр
b	Хувь хүн	2	Олон улсын хэмжээнд мансууруулах бодис, санхүүгийн луйвар, террорист халдлага түгээмэл үйлддэг.
c	Гэмт хэргийн сүлжээ байгууллага	3	Билл Гейтс, Далай лам
d	Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4	CNN
e	Террорист ба зэвсэгт бүлэглэлүүд	5	KFC, Toyota, Nissan